

## 2019 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.01.16

Онгон

Багийн дарга нар 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлын саналыг маягтын дагуу авлаа. Үүнд Их боригдойн 2р баг 75, Донгитын 3-р баг 45, Ар хөшөөтийн 4-р баг 60, Онгоны 5-р баг 69 нийт 249 өрх, иргэнээс санал авлаа. Баг тус бүр эдгээр авсан саналаа нэгтгэн урьдчилсан жагсаалт бэлтгэн багийн иргэдийн нийтийн хуралд оруулж хэлэлцүүлээ. Багийн иргэдийн нийтийн хурлууд 5-р сарын 26-30-ны өдрүүдэд болж ирсэн саналуудыг эрэмбэлж, мөн өмнөх онд авсан санал, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын талаар мэдээлэл хүргэж ажиллаа. Энэ хурлаас БИНХ-ын тогтоол гарч тогтоолыг үндэслэн багийн дарга нар багаас гарч дэмжигдсэн саналуудыг албан тоотоор ЗДТГ-т ирүүлсэн байна. Сангийн сайдын 2018 оны 228 тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын дагуу Засаг даргын 2019 оны 4 сарын 15 нд А/50 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээг эрэмбэлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаа. Энэ ажлын хэсэг багаас ирсэн саналуудыг сумын хөгжлийн бодлого чиглэлтэйгээ уялдуулан 2019 оны 06 сарын 24-ны өдөр авч хэлэлцэн журмын дагуу 3 аргаар үнэлж гарсан үнэлгээ дүгнэлтээ хурлын тэмдэглэлийн хамт засаг даргад өргөн барьлаа.

Сумын засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх эдгээр саналуудыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж жагсаалт гарган Сумын ИТХ-аар батлуулсан болно

ОНХС-ийн хөрөнгөөр 4 ажил хийхээр сумын ИТХ-аас баталсан. Үүнд:

1. Сумын төвийн гэрэлтүүлэг камержуулалт
  2. ЭМТ-ийн бариа заслын төв тохижуулах
  3. Хүүхэд залуучуудын төвийг тоног төхөөрөмжөөр хангах
  4. ЕБС-ийн ширээ сандал авах
- Сумын төвийн гэрэлтүүлэг камержуулалтын тендерийг цахимаар зарлахад 3 аж ахуйн нэгжээс үнийн санал ирсэн. / Богдын буян ХХК, Өрнөх мэргэн ХХК, ЭС ЖИ ЭМ ХХК / Эдгээр аж ахуйн нэгжээс ЭС ЖИ ЭМ ХХК шалгарч тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлыг гүйцэтгэж дууссан учир 8 сарын 19-нд ажлын хэсэг хүлээн авсан./ төсөв- 59818199 төг/
  - ЭМТ-ийн бариа заслын төв тохижуулах ажлыг мөн цахимаар зарласан. Тендерт ЭС ЖИ ЭМ ХХК үнийн санал ирүүлсэн. Энэ компанитай гэрээ байгуулан ажлыг хийлгэн 8 сарын 19-нд хүлээн авсан./ төсөв.24800732 төг/

- Хүүхэд залуучуудын төвийг тоног төхөөрөмжөөр хангах тендерийг цахимаар зарлахад Богдын буян ХХК үнийн санал ирүүлж гэрээ байгуулж 12-р сарын 22-нд ажлын хэсэг хүлээн авсан. / төсөв -22990000 төг/
- ЕБС-ийн ширээ сандал авах тендерийг 2 удаа цахимаар зарлахад эхний удаад 1 аж ахуйн нэгж үнийн санал ирсэн / Амадо ХХК/ бөгөөд гэрээ байгуулахаар тохиролцоход үл ойлголцол гарсан тул , дахин зарласан. 2 дахь удаа зарлахад Онцгой өргөө ХХК, Монгео саплай ХХК гэсэн 2 аж ахуйн нэгж үнийн санал ирсэн. Онцгой өргөө ХХК шалгарч гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан. Хүүхдийн ширээ сандалыг 2020 оны 01 дугаар сарын 06-д хүлээн авсан байна. /төсөв-11800000 төг/
- Мөн 2018 оны хийгдээгүй ажил болох ЗДТГ-ын өмнөх талбайг Сант хүрэн овоо ХХК гүйцээж хүлээлгэн өглөө. / төсөв-21850000 төг/.

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА

Ц.МАРТ

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Б.ГАЧМАА